# ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН 2018 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДРИЙН 1/3753 ТООТ АЛБАН БИЧГЭЭР ИРҮҮЛСЭН ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

2018.10.15

Дархан

| № | Зохион байгуулах арга хэмжээ | Хэрэгжилт |
|---|---|---|
| ***Зөвлөмж 1.*** *Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулахгүйгээр томилох, томилсны дараа хянуулах зөрчлийг зогсоох* | | |
| 1. | Томилох эрх бүхий албан тушаалтнуудад Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар сургалт хийх, ямар албан тушаалд ХАСУМ хянуулах шаардлагатайг ялгаж хэлж өгөх, бүрдүүлэх материал, холбогдох мэдээллийг өгөх | Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар ХАСХОМ гаргадаг эрх бүхий албан тушаалтнуудад сургалтыг 2018.01.15-ны өдөр зохион байгуулсан.<br>Тус байгууллагад ахлах нягтлан бодогчоор ажилд орохоор нэр дэвшсэн албан хаагчийн ХАСУМ хянуулах шаардлагатайг хэлж, бүрдүүлэх материал, холбогдох мэдээллийг өгсөн. |
| 2. | ХАСУМ хянуулсан байдлыг төрийн байгууллагуудад шалгах, бүртгэлтэй танилцах, илэрсэн зөрчлийг арилгуулах, хариуцлага тооцох | Тус байгууллагын ахлах нягтлан бодогчоор ажилд орохоор нэр дэвшсэн албан хаагчийн ХАСУМ болон холбогдох материалыг хянуулахаар 2018.10.12-ны өдрийн 984 албан тоотоор АТГ-т хүргүүлсэн. |
| ***Зөвлөмж 2.*** *Нийтийн албан тушаалтан Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг /ХАСХОМ/-ээ хуульд заасан хугацаанд гаргасан эсэхэд тавих хяналтыг чангатгах, зөрчил гаргасан тохиолдолд хуульд заасан хариуцлагыг ногдуулдаг байх* | | |
| 1. | ХАСХОМ-г хугацаанд нь гаргуулан авч байх | Байгууллагын ХАСХОМ гаргадаг эрх бүхий 3-н албан тушаалтны ХАСХОМ-г 2018.02.09-ны өдөр хүлээн авч нягтлан, хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн системд бүртгэж оруулсан. |
| 2. | Хугацаанд нь гаргуулан аваагүй ЭБАТ болон гаргаагүй албан тушаалтанд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан хариуцлагыг хүлээлгэх | Хугацаандаа бүгд гаргасан. |
| ***Зөвлөмж 3.*** *Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд бичгээр мэдэгдэл гаргах, ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсвэл бичгээр тайлбар хийж, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх ажлыг хэвшүүлэх, энэ талаарх мэдээллийг иргэд олон нийтэд ил тод, нээлттэй болгох* | | |
| 1. | Албан тушаалтнаас албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил | Ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл одоогоор гараагүй байна. |

| | | |
|---|---|---|
| | үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд бичгээр мэдэгдэл гаргах бүртгэх хяналт тавих үйл ажиллагааг төрийн байгууллага нэг бүрт хэвшүүлэх, хэрэгжилтийг шалгах | |
| 2. | Дээрх үйл ажиллагаанд байгууллагын удирдлага хяналт тавьж ажиллах | Ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл одоогоор гараагүй байна. |
| 3. | Албан тушаалтнаас албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд бичгээр мэдэгдлийн талаарх мэдээллийг иргэд олон нийтэд ил тод, нээлттэй болгох | |
| 4. | Эрх бүхий албан тушаалтныг тогтвор суурьшилтай ажиллуулах, холбогдох нэмэгдлийг өгч байх, солигдсон тохиолдолд нэн даруй холбогдох байгууллагад /аймгийн ЗДТГ, дээд шатны байгууллагын ЭБАТ-д/ мэдэгдэх, тухайн албан тушаалтныг сургалтанд хамруулах, | ЭБАТ-ын тогтвор сурьшилтай ажиллуулж байгаа бөгөөд 35 хувийн нэмэгдлийг өгч байна. |
| ***Зөвлөмж 4.*** Иргэнийг хуульд заасан болзол, журмын дагуу төрийн албанд орох адил тэгш боломжоор хангах, төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөхдөө хууль тогтоомжийн дагуу мэргэжлийн шалгалт өгөөгүй, төрийн албаны нөөцөд бүртгэгдээгүй иргэнийг томилдог зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахаас урьдчилан сэргийлэх, шинээр болон дэвшүүлэн томилохдоо мерит зарчмыг удирдлага болгон ажиллах | | |
| 1. | Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, УИХ-ын 2003 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам", Засгийн газрын 2011 оны 62 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журам"-ыг мөрдөж ажиллах, хэвшүүлэх | Засгийн газрын 2011 оны 62 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.9 дэх заалтын дагуу Ү.Оюундарийг Шарын гол сумын газрын даамлаар 2018.08.20-ны өдрөөс эхлэн жирэмсний болон амаржсаны амралттай байгаа Д.Болорцэцэгийн оронд томилон ажиллуулж байна.<br>Мөн тус байгууллагын инженерийн дэд бүтцийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Дархан сумын газрын даамал, Орхон сумын газрын даамал, мэдээлэл технологийн асуудал хариуцсан мэргэжилтний сул орон тоог зарлуулахаар Төрийн албаны зөвлөлийн Дархан-Уул аймаг дахь салбар зөвлөлд 2018.09.07-ны өдрийн 852 тоот албан бичгээр хүргүүлсэн. |
| ***Зөвлөмж 5.*** Төрийн албан хаагчдыг зөвхөн хуульд заасан үндэслэлээр ажлаас чөлөөлөх, үндэслэлгүйгээр ажлаас чөлөөлсний улмаас төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж байгаа зөрчлийг давтан гаргахаас урьдчилан сэргийлэх, хууль бус шийдвэр гаргасан тохиолдолд учруулсан хохирлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх асуудлыг Иргэний хууль, Захиргааны ерөнхий хуулийн дагуу шийдвэрлүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах | | |
| 1. | Төрийн албан хаагчийг ажлаас үндэслэлгүйгээр халсаны улмаас ажилгүй байх хугацааны цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл зэргийг байгууллагаас нөхөн төлж төсвийг үр дүнгүй зарцуулсан тул учирсан | Байхгүй |

| | | |
|---|---|---|
| | хохиролыг буруу шийдвэр гаргасан албан тушаалтнаар төлүүлэх арга хэмжээг авах | |
| 2. | Дээрх зорилгоор Иргэний хууль, Захиргааны ерөнхий хуулийн дагуу шийдвэрлүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах | |
| **Зөвлөмж 6.** Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-нд хариуцан болон хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээг зохион байгуулах, биелэлтийг хангаж ажиллах, үр дүнг цахим хуудсанд байршуулах, олон нийтэд мэдээлэх ажлыг хэвшүүлэх. | | |
| 1. | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг гаргаж аймгийн Засаг даргын орлогчоор батлуулах | 2018.04.11-ний өдөр ГХБХБГ-ын 2018 оны авлигатай тэмцэх, шударга ёс, ил тод байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөг байгууллагын даргаар батлуулсан. |
| 2. | "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-нд хариуцан болон хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээг зохион байгуулах, биелэлтийг хангаж ажиллах, үр дүнг АТГ-т хүргүүлэх, цахим хуудаст байршуулах олон нийтэд мэдээлэх | Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрэм, Авлигатай тэмцэх, шударга ёс, ил тод байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө, 2017 оны ГХБХБГ-ын авлигатай тэмцэх, шударга ёс, ил тод байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, 2018 оны Авлигатай тэмцэх, шударга ёс, ил тод байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөг байгууллагын www.darkhan.gazar.gov.mn цахим хуудасны ил тод байдлын авлигатай тэмцэх цонхонд ил тод нээлттэй байшуулсан.<br>2018 оны төлөвлөгөөний хэрэгжилт 12 сард гарахаар байгууллагын цахим хуудсанд байршуулна. |
| **Зөвлөмж 7.** Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлэх, мэдээллийн цахим сан үүсгэж үйл ажиллагаандаа ашиглах замаар үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах чиглэлээр тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэх. | | |
| 1. | Цахим хэлбэрт шилжүүлэх төрийн үйлчилгээний жагсаалтыг гаргаж 2018 онд нэвтрүүлэх ажил үйлчилгээг тодорхойлох | 2018 онд газар эзэмшүүлэх дуудлага худалдааг Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын дагуу газрын цахим биржийн www.mle.mn цахим хуудсаар 4 удаа зохион байгуулсан. |
| **Зөвлөмж 8.** Сахилга, ёс зүйн зөрчил болон өргөдөл, гомдолд дүн шинжилгээ тогтмол хийх, зөрчил дутагдлын шалтгаан нөхцөлийг арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах, ил тод байдлыг хангах арга хэмжээ авч ажиллах. | | |
| 1 | Ёс зүйн хорооны хурлыг тогтмолжуулах, үйл ажиллагааг жигдрүүлэх, | ГХБХБГ-ын даргын 2018.09.26-ны өдрийн А/39 дугаар тушаалаар байгууллагын ёс зүйн хороог шинэчлэн байгуулсан. |
| 2 | Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил арга хэмжээг авч хэрэгжүүлэх,<br>Ёс зүйн зөрчил, түүнийг шийдвэрлэсэн талаар мэдээллийн сан үүсгэх, олон нийтэд мэдээлэх нөхцлийг бүрдүүлэх, мэдээлэх | ГХБХБГ-ын даргын 2017.02.13-ны өдрийн А/02 дугаар тушаалаар Байгууллагын ёс зүйн хорооны ажиллах журам, ёс зүйн дүрмийг тус тус баталсан.<br>Аймгийн Засаг даргын 2018 оны 1-04/02 албан даалгаврын хэрэгжилтийг хангалтгүй биелүүлсэн, тайлан мэдээг удаа дараа хугацаанд нь ирүүлээгүй Хонгор сумын газрын даамал Ц.Базарсад, Орхон сумын |

| | | |
|---|---|---|
| | | газрын даамал Ч.Үүрийнтуяа, Шарын гол сумын газрын даамал Д.Болорцэцэг нарт Төрийн албаны тухай хуулийн 26.1.1 дэх заалтын дагуу сануулах арга хэмжээг ГХБХБГ-ын даргын 2018.06.19-ны өдрийн А/33 дугаар тушаалаар авсан. |

ХЭРЭГЖИЛТ ГАРГАСАН:

МЭРГЭЖИЛТЭН: Ч.АНХБАЯР

ХЯНАСАН:

ГАЗРЫН ДАРГА: Д.ГАНБАЯР